



ГАРЧИГ

- 2–3 Бодлогын нийтлэл
- 4–7 Зохицуулалтын мэдээ
- 8–10 Ярилцлага
- 11–12 Тогтвортой санхүүжилт
- 13–14 Компанийн засаглал, комплайнс
- 15–16 Финтек ба регтек
- 17–23 Судлаачийн индэр
- 24–25 Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын гэрээ байгуулахдаа юу анхаарах вэ?
- 26–27 Олон улсын зах зээлийн мэдээ
- 28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ФИНТЕК БА РЕГТЕК ДЭХ ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ (AI) ХЭРЭГЛЭЭ



Сүүлийн жилүүдэд хиймэл оюун ухаан (AI) нь санхүүгийн салбарт хувьсгал авчирч, финтек болон регтекийн хөгжлийг шинэ түвшинд хүргэж байна. Энэхүү технологи нь зөвхөн санхүүгийн үйлчилгээний

хурд, хүртээмжийг нэмэгдүүлээд зогсохгүй, салбарын аюулгүй байдал, зохицуулалтын нийцлийг хангах инновацийн шинэ боломжуудыг нээж өгч байна. Иймд сэтгүүлийн энэ удаагийн дугаараар хиймэл оюун ухааны финтек болон регтек дэх хэрэглээний талаарх мэдээллийг хүргэхээр бэлтгэлээ.

Финтек дэх хиймэл оюун ухаан

Хиймэл оюун ухаан нь финтекийн экосистемд эрсдэлийн менежментээс эхлээд хэрэглэгчийн үйлчилгээг сайжруулах, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг чиглэлд нөлөөллөө үзүүлж байна. Тодруулбал, хиймэл оюун ухааны тусламжтайгаар санхүүгийн байгууллагууд хувь хүн бүрийн онцлогт тохирсон санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх боломж бүрдсэн бөгөөд үүний нэг жишээ нь Betterment, Wealthfront зэрэг хиймэл оюун ухаанд суурилсан хэрэглэгчийн өгөгдлийг шинжлэн хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгдөг робот зөвлөхүүд юм. Эдгээр хиймэл оюун ухааны хэрэгслүүд нь уламжлалт санхүүгийн зөвлөхийн оронд хямд, хүртээмжтэй шийдлийг санал болгодог байна.

Бас нэгэн чухал хэрэглээ нь санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа юм. Хиймэл оюун ухаанд суурилсан алгоритмууд нь санхүүгийн гүйлгээний хэв маягийг шинжлэн сэжигтэй үйлдлийг илрүүлэх байдлаар залиланг багасгахад тусалдаг. Жишээ нь, PayPal компани хиймэл оюун ухаан ашиглан сая сая гүйлгээг бодит цаг хугацаанд шинжилж, сэжигтэй гүйлгээг илрүүлж, залилангаас урьдчилан сэргийлдэг. Үүнтэй адилаар, ZestFinance зэрэг хиймэл оюун ухаанд суурилсан зээлийн онооны загварууд нь машин сургалтыг ашиглан зээлийн чадварыг үнэлж, уламжлалт зээлийн түүхгүй иргэдэд санхүүгийн үйлчилгээ авах боломжийг нээж өгч байна.

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН ШИНЭЧЛЭЛ



Жендер бонд

Gender bond

Жендерийн тэгш байдлын ойлголтыг дээшлүүлэх, эмэгтэйчүүдийг чадавхжуулах зорилго бүхий төслийг санхүүжүүлэх зорилготой өрийн бичиг. Жендерийн бондын зорилго нь бонд гаргах замаар жендерийн тэгш байдлыг хангахад түлхэц болох хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах явдал юм.



Компанийн нийгмийн хариуцлага

(CSR) /Corporate Social Responsibility

(CSR)/Компани бий болгосон ашгаасаа оролцогч талууд болон нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй хөрөнгө оруулалт хийж буй хэлбэр.

Эх сурвалж: Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь

УИХ-аас 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг баталснаар Монгол Улсад мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь бүртгэх байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн зохицуулалттай болсон. Өмнө нь ямарваа нэгэн зохицуулалтгүйгээр үйл ажиллагаа явуулж байсан тус салбарыг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль батлагдсанаар бүртгэл, зохицуулалттай болсон тул хуулийг хэрэгжүүлэх мөн таниулах хүрээнд бүртгэлтэй холбогдох ажиллагаануудыг тус бүрт нь зохицуулахаар Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 81 дүгээр тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”, 82 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан, мэдээ ирүүлэх журам”, 2024 оны 162 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”-ыг баталж мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, зохицуулалтыг олон нийт болон бүртгэх байгууллагуудад хэвшүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, бүртгэлд өөрчлөлт оруулах, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, тайлан мэдээ илгээх зэрэг үндсэндээ бүртгэлтэй холбоотой харилцааг дээрх 3 журмаар сүүлийн 2 жилийн хугацаанд зохицуулж Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг иргэд олон нийт, үйл ажиллагаа эрхлэгч болон бүртгэх байгууллагуудад таниулах ажиллагааг хийх анхны зорилгодоо хүрсэн байна.

Иймд дээрх 3 журмын агуулга нь үндсэндээ бүртгэлтэй холбоотой харилцааг зохицуулдаг тул бүртгэлийн үйл ажиллагааг илүү хялбарчлах, нэгтгэн бүлэглэх боломжтой төдийгүй зээлдэгчдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээллийг тайлан мэдээнд тусгах, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгүүлэх иргэн, хуулийн этгээдийн хувьд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг ялгамжтай байдлаар тодорхойлох нь өргөдөл гаргагчид журмын хэрэглээг ойлгомжтой, хялбар болгох давуу талтай байх тул дээрх 3 журмыг нэгтгэн Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 641 дүгээр тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн батлаад байна.

Тус журмыг шинэчлэн баталснаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн хүрээнд явагдаж буй бүртгэлийн үйл ажиллагааг илүү

хялбарчлах, иргэд олон нийтэд олон дүрэм, журмаар бус нэг хэм хэмжээний актын дагуу үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийг хийлгэх, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нэгдсэн тоо мэдээ гаргах, зээлдэгчдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээллээр хангагдах, бүртгэх байгууллага буюу аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг дарга, Санхүүгийн зохицуулах хорооны хувьд бүртгэлийн өөрчлөлтийг бүртгэх үйл ажиллагааг хялбарчлах, өргөдөл гаргагчид бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг олон журмаар бус нэг журмын дагуу хэрэглээг ойлгомжтой, хялбар болгох нөхцөл бүрдэж байна.

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн тайлан мэдээ илгээх цахим систем ашиглалтад орно

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийн талаарх мэдээллийг агуулсан цахим мэдээллийн санд холбогдсон байх, барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бол тухайн мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг агуулсан цахим бүртгэлтэй байх, тус цахим бүртгэлд зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээг барьцаа хөрөнгийн гэрэл зургийн хамт бүртгэх зэрэг зохицуулалтууд тусгагдсан.

Хуулийн энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээ бүртгэх, барьцаа хөрөнгийг гэрэл зургаар баталгаажуулах, шаардлагатай тайлан мэдээ бэлтгэх, цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийн цахим мэдээллийн сантай холбогдсон нэгдсэн системийг бүтээгээд байна. Энэхүү систем ашиглалтад орсноор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийг үнэн зөв хөтлөх, тайлан мэдээ бэлтгэх ажиллагааг автоматжуулах, хулгайд алдагдсан эд зүйлсийг барьцаанд авахаас сэргийлэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн хэрэглэгчийг таньж мэдэх үүргээ бүрэн хэрэгжүүлэх зэрэг боломжуудыг бүрдүүлэхээс гадна хүнээс үүдэлтэй алдаа дутагдлыг багасгах давуу талыг бий болгох юм. Мөн түүнчлэн зохицуулагч байгууллагыг бодит цагийн горимд суурилсан салбарын өнөөгийн байдал, статистик тоон мэдээллээр хангах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бий болгох, регтек буюу техникт суурилсан зайны хяналтыг оновчтой хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм.



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
БОЛОВСРОЛЫГ ТҮГЭЭНЭ

**МӨНГӨН ШИЙДВЭР
ХӨРӨНГӨ БОЛОХГҮЙ**

ЗААВАЛ УНШИХ МЭДЭЭЛЭЛ
QR КОДОО УНШУУЛААРАЙ

зохицуулсан байдаг. Хуулийн 17.4.2-д “мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох” гэж заасантай холбоотойгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчид болон иргэдийн төлөөлөл оролцсон “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа” хэлэлцүүлгийг Санхүүгийн зохицуулах хорооны Санхүүгийн хүртээмж танхимд зохион байгууллаа.

Хэлэлцүүлгээр зээлийн хүүгийн дээд хязгаарын харьцуулсан судалгаа, салбарын өнөөгийн байдал, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тайлан хүлээж авах, боловсруулах, бүртгэх цахим системийн талаар танилцуулсны сацуу цаг үеийн тулгамдаж буй асуудал, зээлийн хүүгийн хэмжээ, үйл ажиллагаа явуулах зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлуудын талаар хэлэлцэж оролцогчдын гаргасан саналыг Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлд танилцуулахаар боллоо. Мөн хэлэлцүүлгийн үеэр СЭЗИС-ийн ахисан түвшний профессор З.Оюунцацрал “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг гадаад улс орнуудтай харьцуулсан судалгаа”-г танилцуулсан юм.

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО



УИХ-аас Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг баталж, хуулийн хэрэгжилтийг 2023 оны гуравдугаар сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр хуульчилсан. Энэ хуулийн зорилго нь барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагааг байнга, ашиг олох зорилгоор эрхлэх иргэнийг бүртгэх, хяналт тавих, тэдгээрээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, зээл, түүний хүүг төлөх болон мөнгөн зээлийн үйл ажиллагаанд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭРГЭШЛИЙН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА



Үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах түүнтэй холбоотой сургалтын хөтөлбөрийг батлах, шалгалтыг зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий мэргэшлийн зөвлөлийн хурал боллоо. Хуралдаанаар мэргэшлийн зөвлөлийн өнгөрсөн оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, энэ онд зохион байгуулах үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх олгох сургалтын хөтөлбөр, шалгалтын хуваарыг хэлэлцэн батлав.

2024 онд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил,

үйлчилгээ явуулах эрх олгох шалгалтыг хоёр удаа зохион байгуулж, нийт 353 мэргэжилтэнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг олгосон. Харин энэ жил эрх олгох сургалтыг ирэх 4, 11 дүгээр сард зохион байгуулахаар хуралдаанаар шийдвэрлэлээ. Мөн “Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, үргэлжилсэн сургалт зохион байгуулах журам”-ын төслийг хэлэлцэж, санал солилцсон юм.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадралаар ахлуулсан тус мэргэшлийн зөвлөлд СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Компанийн засаглал, комплайнсын хэлтсийн дарга А.Авир, Үнэт цаасны газрын ахлах референт Н.Энхбаатар, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хяналт, зохицуулалтын газрын захирал А.Мөнхбаясгалан, МҮЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн А.Өлзийдэлгэр, “Тасралтгүй боловсрол судалгааны институт” ХХК-ийн захирал С.Өнөр, МУИС-ын Бизнесийн сургуулийн багш Д.Одбилэг нар гишүүнээр ажилладаг.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ “LEVEL-UP” ХӨТӨЛБӨР УВС АЙМАГТ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжихэд иргэдийн санхүүгийн мэдлэг боловсрол, оролцоо чухал үүрэгтэй билээ. Иймд УИХ-ын даргын санаачилгаар ахлах ангийн сурагчдад санхүүгийн боловсрол олгох “Level-Up” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд Увс аймагт нээлтээ хийлээ. Нээлтэд УИХ-ын дарга Д.Амарбаясгалан, УИХ-ын гишүүн Э.Болормаа, М.Мандхай, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Увс аймгийн Засаг дарга С.Батжаргал болон холбогдох албаны хүмүүс оролцов.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц “Иргэн бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварын нэг нь яахын аргагүй санхүүгийн боловсрол, зөв дадал зуршил. Хүүхэд залуус та бүхэн нийгмийн харилцаанд оролцох явцад олон боломж гарч ирэхийн зэрэгцээ түүнийг дагаад бэрхшээлүүд ч тулгарах нь цөөнгүй. Боломж, сорилт бүхний цаана тодорхой хэмжээнд эрсдэл байдаг тул санхүүгийн боловсролтой, мэдлэгтэй иргэн байж санхүүгийн хуримтлал, хөрөнгө оруулалт, өр зээл гэж юу болох, санхүүгийн залилан, луйвраас сэргийлж чаддаг, таньж чаддаг, өөрийгөө болон гэр бүл, найз нөхдөө хамгаалах мэдлэгтэй байх нь чухал. Ийм учраас санхүүгийн боловсролыг илүү хүртээмжтэй, үр дүнтэй хүргэх хүрээнд олон арга хэмжээг хэрэгжүүлж байгаагийн нэг нь энэ хөтөлбөр юм. Ингээд Монгол Улсын ирээдүйн хөгжлийг тодорхойлох сурагч багачууддаа санхүүгийн зөв дадал, зуршлыг бүрдүүлж, мөрөөдөлдөө хүрэхийн тулд өөрийгөө хөгжүүлж, мэдлэг, боловсрол олж авахад анхаараарай гэж захиж байна” гэдгийг онцлов.

Энэ үеэр “Санхүүгийн боловсрол-миний амьдралд” хэлэлцүүлэг өрнүүлсний зэрэгцээ хадгаламжийн болон хөрөнгө оруулалтын сертификат гардууллаа. Хөтөлбөрийн хугацаанд сурагчид өдөр тутмын санхүүгээ зохистой төлөвлөх, зарцуулалтаа хянах, эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх аргад суралцах замаар санхүүгийн зөв соёл, зан үйлд суралцах юм.

“LEVEL-UP” ХӨТӨЛБӨРИЙН НЭЭЛТ ОРХОН, БУЛГАН АЙМАГТ БОЛЛОО

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгох замаар ирээдүйд санхүүгийн зохистой шийдвэр гаргадаг, эрсдэлийг үнэлэх чадвартай иргэнийг бий болгож төлөвшүүлэх, зөв дадал, чадварт суралцахад нь сургууль, багш нарын үүрэг, оролцоо, манлайллыг дэмжих, зорилготой “LEVEL-UP” хөтөлбөрийн нээлт Орхон, Булган аймагт боллоо. Хөтөлбөрийн нээлтэд УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа, УИХ-ын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван болон холбогдох албаны бусад хүмүүс оролцов.



Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага. Энэ үүднээс иргэд олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон их дээд сургуулийн оюутан, залуучуудын дунд сургалт, уралдаан, тэмцээнийг тогтмол зохион байгуулдаг. Өөрөөр хэлбэл залуус санхүүгийн боловсролтой болсноор хувийн санхүүгээ зөв төлөвлөж сурахын зэрэгцээ аливаа санхүүгийн залилан, эрсдэлээс өөрийгөө хамгаалах чадвартай болно гэж үздэг. Сурагчид та бүхэн энэхүү хөтөлбөрт хамрагдсанаар хуримтлал, хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, даатгал зэрэг санхүүгийн олон бүтээгдэхүүний талаар мэдлэг, мэдээлэл авч байгаа. Тэр дундаа хуримтлал хийх дадал, хэвшлийг багаасаа олж авах нь чухал юм. Мөн санхүүгийн залилан, луйвраас өөрийгөө болон найз нөхдөө хамгаалах чадвар, мэдлэг, мэдээлэлтэй болоход “Level-Up” хөтөлбөрийн зорилго оршиж байгаа” гэдгийг онцолсон юм.

УИХ-ын Тамгын газар, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Боловсролын ерөнхий газар хамтран зохион байгуулж буй энэхүү хөтөлбөрийн хугацаанд сурагчид өдөр тутмын санхүүгээ зохистой төлөвлөх, зарцуулалтаа хянах, эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх аргад суралцах замаар санхүүгийн зөв соёл, зан үйлд суралцах юм.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ БОЛОВ



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөлийн хурал Санхүүгийн зохицуулах хорооны байранд боллоо. Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хамтын ажиллагааны зөвлөлийн дарга Н.Хүдэрчулуун хурлыг нээн үг хэлж, шинэчилсэн аргачлалтай нийцүүлж мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх харилцан үнэлгээнд бэлтгэх, холбогдох ажлуудыг эрчимжүүлэх шаардлагатайг онцлов.

Хурлаар Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Ганчимэг Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Олон улсын хамтарсан бүлэгт ажилласан туршлагаасаа хуваалцаж, харилцан үнэлгээний тайлан бэлтгэх, статистик тоо мэдээлэл нэгтгэх, тайлагнахтай холбоотой мэдээллийг өгөв. Мөн Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанаас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны биелэлтийг танилцуулав. Түүнчлэн Монгол Улсын 2025 оны явцын тайланг Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлэх, Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх дэд ажлын хэсгүүдийн хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг шинэчлэх, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулах тухай асуудлуудыг тус тус хэлэлцүүлж, холбогдох шийдвэрүүдийг гаргалаа.

“LEVEL-UP” ХӨТӨЛБӨРИЙН НЭЭЛТ ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ БОЛЛОО




Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгох замаар ирээдүйд санхүүгийн зохистой шийдвэр гаргадаг, эрсдэлийг үнэлэх чадвартай иргэнийг бий болгож төлөвшүүлэх, зөв дадал, чадварт суралцахад нь сургууль, багш нарын үүрэг, оролцоо, манлайллыг дэмжих, зорилготой “LEVEL-UP” хөтөлбөрийн нээлт Говь-Алтай аймагт боллоо. Хөтөлбөрийн нээлтэд Санхүүгийн зохицуулах хорооны

дарга Т.Жамбаажамц, Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Говь-Алтай аймгийн Засаг дарга Г.Чинбат болон холбогдох албаны бусад хүмүүс оролцов.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц нээж хэлсэн үгэндээ "Монгол Улсын ирээдүй хойч болсон хүүхэд залуусдаа энэ өдрийн мэнд хүргэе. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын төрөөс бүх насны иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд анхаарч, үе шаттай арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлж байгаа ба үүний нэг нь энэ хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөр нь ирээдүйд өөрийн хүч хөдөлмөрөөрөө бий болгосон санхүүгээ зөв удирдаж, хуримтлалтай, эрсдэл багатай хөрөнгө оруулалт хийж чаддаг, ингэснээр өөрийгөө болон гэр бүлдээ учирч болох аливаа эрсдэлээс сэргийлэх чадвартай, санхүүгийн хувьд ирээдүйдээ итгэлтэй ийм л иргэн болгож төлөвшүүлэхэд гол ач холбогдол оршиж байгаа. Сүүлийн жилүүдэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд цахим технологид суурилан орон зай, цаг хугацааг үл харгалзан хүн бүрт хүрэх болсон. Гэхдээ технологийн энэ дэвшил нь нөгөө талаар санхүүгийн залилан, луйвар, тэр дундаа өсвөр насны залуучуудын санхүүгийн мэдлэг, мэдээлэл дутмаг байдлыг ашиглаж гэмт хэргийн хохирогч болгох явдал ихсэж байна. Иймд санхүүгийн луйварт өртөхгүй байж, өөрийгөө хамгаалах чадвартай болохын тулд хөтөлбөрийн хүрээнд заагдах сургалт, хичээлийг хичээнгүйлэн сонирхож, шамдан суралцаасай гэж хүсэж байна. Мөн манай байгууллагын фэйсбүүк, инстаграм, твиттер зэрэг олон нийтийн цахим сүлжээнээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга, санхүүгийн гэмт хэргийг хэрхэн таних, өөрийгөө яаж хамгаалах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч болно. Цаашилбал хөрөнгийн зах зээл, даатгал, хадгаламж, зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллага, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн талаарх мэдээ, тойм, судалгааны материалыг олон нийтэд ил тод байдлаар хүргэдэг тул энэ чиглэлд илүү гүнзгийрүүлж судалж сонирхох бүрэн боломжтой" гэдгийг онцолсон юм.

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМЫГ POWER BI ДАШБОАРДООР МЭДЭЭЛДЭГ БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хороо иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, ил тод, нээлттэй байдлаа нэмэгдүүлэх зорилгоор зохицуулалттай салбаруудын голлох тоон үзүүлэлтүүдийг POWER BI дашбоардоор мэдээлдэг боллоо. Энэхүү дашбоард нь хөрөнгийн зах зээл, банк бус санхүүгийн байгууллага, даатгал, хадгаламж зээлийн хоршоо, үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн салбар, сэндроксын зохицуулалтын орчин болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын улирлын тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн цаг хугацааны эрэмбээр харуулах тул Та бүхэн сонирхсон салбарын мэдээллээ он, улирлаар нь сонгож мэдээллийг авах боломжтой.

Хэрэглэгч, үйлчлүүлэгч танд энэхүү дашбоард нь санхүүгийн салбарын тоо мэдээ, үзүүлэлтүүдэд үндэслэж бизнесийн ажиллагааны төлөвлөлт гаргах, төлөвлөлтөө гаргах, дүн шинжилгээ хийх, санхүүгийн оновчтой шийдвэр гаргалтад тань туслахаас гадна оюутан, судлаач нарыг санхүүгийн салбарт судалгаа хийхэд үнэтэй хувь нэмэр оруулах болно.

"СЭНДБОКСЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ЖУРАМ"-ЫН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ДЭМЖЛЭЭ

Сэндроксын зөвлөлийн ээлжит хуралдаан боллоо. Хуралдаанаар сэндроксын орчинд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ турших, сэндроксын туршилтын хугацааг сунгах, зохицуулалтын орчноос шилжих, гаргах болон "Сэндроксын зохицуулалтын орчны журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг нийт долоон асуудал хэлэлцлээ.

Хуралдааны үр дүнд "Сэндроксын зохицуулалтын орчны журам"-ын нэмэлт өөрчлөлтийг дэмжих, "Фандиа" ХХК-ийн урамшуулал, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг сэндроксын зохицуулалтын орчноос гаргах, хувьцааны хамтын санхүүжилтийн үйлчилгээг сэндрокс зохицуулалтын орчинд үргэлжлүүлэн зургаан сарын хугацаанд турших зөвлөмжийг гаргалаа. Мөн "Фанд Ми Бирж" ХХК-ийн хөгжүүлж буй богино хугацаат санхүүжилтийн зуучлал B2B зээлийн үйлчилгээний сэндроксын туршилтын хугацааг нэг жилээр үргэлжлүүлж сунгах, "Зээл Эм Эн Платформ ББСБ" ХХК болон "Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо" ГҮТББ-ын сэндроксын зохицуулалтын орчноос шилжих төлөвлөгөөг хэрэгжүүлэх, "Финберри" ХХК-ийн хамтын санхүүжилтийн үйлчилгээг сэндрокс зохицуулалтын орчноос гаргах, "Мони Маркет Фанд" ХХК-ийн сэндрокс зохицуулалтын орчноос шилжих хугацааг сунгах, нэмэлтээр турших үйлчилгээнд хязгаарлалт тогтоох зэрэг зөвлөмжийг тус, тус гаргалаа.

ЯРИЛЦЛАГА

ИПОТЕКИЙН ДААТГАЛЫН ХУВЬД УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛД ХАМРАГДСАНААР ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТЫН ХЭМЖЭЭ 5–6 ДАХИН НЭМЭГДЭНЭ

Ипотекийн зээл буюу орон сууцны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн хэмжээг энэ онд 1.2 их наяд төгрөгт хүргэхээр Засгийн газраас¹ төлөвлөөд байгаа билээ. Тэгвэл энэхүү зээлийг олгоход тавигддаг шаардлагуудын нэг болох ипотекийн даатгал, уг даатгалын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудын талаар Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын референт Ц.Долгорсүрэнгэй ярилцлаа.

Иргэдийн дунд хамгийн их эрэлттэй байдаг зээл бол мэдээж Ипотекийн зээл. Банкууд ипотекийн зээл олгохдоо заавал даатгуулах шаардлага тавьдаг. Ипотекийн зээлийн хувьд иргэд яагаад даатгал хийлгэх хэрэгтэй вэ?

Ипотекийн зээл авч буй иргэдийн хувьд яагаад даатгал зайлшгүй вэ гэдгийг ярихын тулд ипотекийн зээлийн ач холбогдлын талаар товчхон дурдах нь зүйтэй байх. Засгийн газраас иргэдийг орон сууцжуулах урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн 2013 оноос хойш уг хөтөлбөрийн болон бусад санхүүжилтийн эх үүсвэрийн хүрээнд ойролцоогоор 200 гаруй мянган зээлдэгчдэд 11.2 их наяд төгрөгийн ипотекийн зээл олгогдож, орон сууцанд амьдардаг нийт өрхийн тоо 11 гаруй хувиар нэмэгдсэн гэсэн статистик мэдээллүүдийг холбогдох байгууллагуудын эх сурвалжаас олж харж болно. Тэгэхээр ипотекийн зээл нь Монгол Улсын нийт өрхийн тавны нэг нь ая тухтай орчинд амьдрах, тэдгээрийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ яах аргагүй мөн. Нөгөө талаас энэхүү зээл нь барилгын салбар, цаашлаад банк, даатгал, хөрөнгийн зах зээлийн өсөлтөд ч эергээр нөлөөлж, нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа билээ.

Харин ипотекийн даатгалын хувьд Засгийн газрын 2018 оны 369 дүгээр тогтоолоор баталсан “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-ын 4.2.9, Монголбанкны ерөнхийлөгчийн 2008 оны 446 дугаар тушаалаар баталсан “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын 22.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу ипотекийн зээлдэгчдэд зээлийн хугацаа дуустал хугацаанд амь нас, эрүүл мэндийн болон барьцаа хөрөнгийн гэх 2 төрлийн даатгалд хамрагдах шаардлага тавигддаг.

Олон улсын сайн туршлагаас харахад, хөгжингүй орнуудад

орон сууцны урьдчилгаа төлбөр болон орлогын түвшин нь бага, зээл төлөгдөхгүй байх эрсдэл өндөртэй тохиолдолд л зээлдэгч нарыг заавал даатгуулахыг шаарддаг бол хөгжиж буй ихэнх орнуудад манай улстай нэгэн адил зээлдэгчид, тэдгээрийн өрх, гэр бүлийг болзошгүй санхүүгийн хүндрэлээс хамгаалах, зээлийн санхүүжилтийн системийн тогтвортой, тасралтгүй байдлыг хангах зорилгоор бүх зээлдэгчдийг заавал даатгуулдаг байх шаардлагыг тавьдаг байна.

Орон сууц, байрны үнэ, хэрэглээний өртөг, зардлын хэмжээ жилээс жилд нэмэгддэг, иргэд нь хангалттай түвшинд хуримтлал үүсгэж чаддаггүй, орлогын эх үүсвэрийн төрөлжилт багатай, дундаж наслалтын үзүүлэлтээр дэлхийн 210 улсын 133 дугаарт жагсдаг манай улсын хувьд энэхүү даатгал нь ипотекийн зээлдэгчдэд зайлшгүй хэрэгцээтэй даатгал юм. Зээлдэгч даатгуулагчдад учирсан бодит хохирлын тоо мэдээлэл ч үүнийг нотолж байгаа бөгөөд “МИК” ОССК-ийн статистик мэдээллээс харахад 2013 оноос 2024 оныг дуустал хугацаанд зээлдэгч, даатгуулагч нараас зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалтай холбогдох 163 тохиолдлын 6.3 тэрбум төгрөг, барьцаа хөрөнгийн даатгалтай холбоотой 701 тохиолдлын 1.1 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийг тус тус гаргасан байна.

Ипотекийн даатгал нь барьцаа хөрөнгийн болон зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал гэсэн 2 даатгалын бүтээгдэхүүнээс бүрддэг гэж ойлголоо. Тэгвэл эдгээр бүтээгдэхүүний онцлогийн талаар уншигчдад дэлгэрэнгүй мэдээлэл өгөх нь зүйтэй байх. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн даатгалын талаарх мэдээллээр эхлүүлье.

Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн даатгалын хувьд энэ нь ердийн даатгалын ангилалд, түүн дотроо хөрөнгийн даатгалын хэлбэрт хамаардаг бүтээгдэхүүн юм. Өнөөдрийн байдлаар, тус Хорооноос ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 17 компаниас 16 компани нь уг даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж, зах зээл дээр санал болгож байна.

Энэхүү даатгалын бүтээгдэхүүний хувьд гал түймэр, дэлбэрэлт буюу галын эрсдэл, сантехникийн эрсдэл, газар хөдлөлтөөс бусад байгалийн эрсдэл, цахилгаан, эрчим хүчний эрсдэл, гуравдагч этгээдээс учруулсан санаатай болон санамсаргүй үйлдэл гэсэн 5 үндсэн эрсдэлийн улмаас

¹ <https://mcud.gov.mn/a/1492> Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

барьцаа хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд нөхөн төлбөр олгодог. Мөн зээлдэгч хүсвэл даатгагчтай харилцан тохиролцсоны дагуу эдгээр эрсдэлээс гадна нэмэлт эрсдэлээр даатгуулж болдог.

Жишээ нь, галын эрсдэл тохиолдоод зээлийн барьцаа хөрөнгө бүрэн сүйрлээ гэж бодъё, хэрэв ипотекийн барьцаа хөрөнгийн даатгалд даатгуулсан бол зээлдэгч даатгалын үнэлгээтэй тэнцэхүйц мөнгийг даатгагчаас авах нөхцөл бүрдэх ба ингэснээр зээлдэгч дахин шинэ байр худалдан авах санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлж байгаагаараа ач холбогдолтой. Харин эсрэгээр, зээлдэгч барьцаа хөрөнгөө даатгуулаагүй бол галын улмаас байргүй болж, дахин шинэ байр худалдан авах тохиолдолд өөр эх үүсвэрээс мөнгөө бүрдүүлэх шаардлага үүсэх буюу ийм эх үүсвэр байхгүй бол орон байргүй болох хүртэл асуудал үүснэ. Түүнчлэн, энэхүү даатгалд даатгуулсан бол барьцаа хөрөнгө бүрэн сүйрээгүй ч учирсан хохирлыг даатгалаар нөхүүлэн авснаар зээлдэгч тав тухтай орчинд амьдрах, нөгөөтэйгүүр барьцаа хөрөнгийг тухай бүр нөхөн сэргээх боломж бүрдсэнээр хөрөнгийн үнэ цэн алдагдахаас сэргийлэх боломжтой байдаг.

Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн даатгалын нөхөн төлбөрийн хувьд 2024 оны байдлаар даатгалын 7 компани нийт 67 даатгалын гэрээнд хамаарах 931.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч, одоо хүчинтэй байгаа зээлдэгчдийн 57.4 хувь нь л барьцаа хөрөнгөө даатгуулсан үзүүлэлттэй байна.

Энд нэг зүйлийг онцгойлон хэлэхэд, энэхүү ипотекийн барьцаа хөрөнгийн даатгал нь зээлийн төлбөрийг даатгадаггүй ба зээлдэгчийн хувьд зээлийн үлдэгдлийг төлөх үүрэг нь хэвээрээ буюу ипотекийн зээлийн төлбөрөө төлсөөр байх шаардлагатай байдаг. Харин зээлийн үлдэгдэл төлбөрийг төлөх даатгал нь ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал юм.

Тэгвэл, зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын тухайд ямар онцлогтой вэ?

Ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал нь хамгаалж буй эрсдэлээсээ хамаараад 2 төрөлтэй байхаар холбогдох журамд заасан байдаг. Нэг нь, гэнэтийн ослын улмаас даатгуулагчид учрах эрсдэлээс хамгаалах ердийн даатгалын бүтээгдэхүүн, нөгөөх нь, аливаа шалтгааны улмаас даатгуулагчид учрах эрсдэлээс хамгаалах урт хугацааны даатгалын бүтээгдэхүүн юм. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн, ахуйн, зам тээврийн, байгалийн үзэгдэл түүний улмаас үүссэн осол болон бусад этгээдээс шалтгаалан даатгуулагч нас барах, эсхүл хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдах тохиолдлыг ердийн даатгалын компаниуд даатгадаг ба даатгуулагчид

аливаа өвчний улмаас учрах эрсдэлийг тус даатгалаар хамгаалдаггүй. Харин урт хугацааны буюу амьдралын даатгагч нь бүхий л төрлийн эрсдэлийг даатгах боломжтой байдаг.

Зээлдэгч ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулснаар өмнө хэлсэнчлэн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндэд эрсдэл учирч амь насаа алдах, эсхүл хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдсан нөхцөлд үлдсэн зээлийг нь даатгалын компани төлөх нөхцөл бүрдэх буюу даатгуулагч зээл төлөх үүргээс чөлөөлөгдөнөө өө гэсэн үг.

Энэхүү даатгалын бүтээгдэхүүнтэй холбогдох цөөн статистик дурдвал, 2024 оны байдлаар ердийн даатгалын 9 компани 52,650 даатгалын гэрээ байгуулж, 7.1 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлсэн бол 27 даатгуулагчид 1.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон. Харин урт хугацааны даатгагчийн хувьд 32 даатгалын гэрээ байгуулж, 9.9 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүлсэн байна.

Харин 2024 оны байдлаар ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хамрагдалтын хувь нийт ипотекийн зээлийн тоонд харгалзах хэмжээгээр 42.8 хувь байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт юм.

Таны дурдсан статистикаас харахад, ипотекийн даатгалд хамаарах 2 бүтээгдэхүүний хамрагдалт төдийлөн хангалттай бус байна. Тус бүтээгдэхүүний хувьд тулгамдаж буй асуудал юу байна вэ?

Ерөнхийдөө, зээлдэгч ипотекийн даатгалд даатгуулснаар нэгд, зээлээр худалдан авсан хөрөнгө эрсдэлд орсон тохиолдолд дахин худалдан авах эх үүсвэрээ бүрдүүлэх, эсхүл түүнийг нөхөн сэргээх хоёрт, зээлдэгч амь насаа алдах болон хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдах тохиолдолд зээлийн төлбөрийг төлөх үүргээс чөлөөлөгдөх нөхцөл бүрдэх тул зээлдэгчийн хувьд чухал ач холбогдол бүхий даатгал бөгөөд иргэд, зээлдэгчид маань өөрийгөө болон өөрийн гэр бүлийн хүмүүсээ эдгээр эрсдэлээс хамгаалж байгаа гэдгээ ойлгох нь зүйтэй.

Үүний зэрэгцээ ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүний хувьд зайлшгүй дурдах ёстой нэг асуудал байна. Уг даатгал нь ердийн болон урт хугацааны даатгалын ангилалд хамаарах 2 төрөлтэй байдаг гэж өмнө дурдсан. 2016 оноос хойш тус Хороонд ирүүлсэн Ипотекийн даатгалтай холбоотой өргөдөл, гомдлыг авч үзвэл, нийт өргөдлийн 84.5 хувь нь зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн гэнэтийн ослын даатгал, үлдсэн хувь нь барьцаа хөрөнгийн даатгалын асуудлаар хандаж гомдол, хүсэлт гаргажээ. Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалтай холбогдох дээрх өргөдлийн 92.0 хувь нь нөхөн төлбөрийн маргаантай шууд холбогдож байгаа бөгөөд

маргаан үүсэж буй голлох шалтгаан нь зээлдэгчийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын дийлэнх нь өвчний улмаас / тухайлбал: хорт хавдар/ тохиолдсон тул гэнэтийн ослын эрсдэлд хамаардаггүйтэй холбоотой юм.

Ерөнхийдөө, даатгуулагчийн хувьд харьцангуй бага хураамжтай ердийн даатгалын бүтээгдэхүүн буюу зөвхөн гэнэтийн ослын улмаас хохирол учрах эрсдэлийг сонгох нь илүүтэй байна. Ингэснээр даатгуулагчид хамгийн их учирч буй эрсдэл нь даатгалын гэрээгээр хамгаалагдахгүй байх, даатгалын гэрээний хугацаа богино байдгийн улмаас даатгалын хураамж төлөгдөхгүй, гэрээ сунгагдахгүй буюу даатгалын хамгаалалт дуусгавар болсон байх зэрэг эрсдэлүүд бий болж байна.

Эдгээр эрсдэлүүдээс үүдэлтэйгээр зээлдэгчийн амь нас, эрүүл мэнд хохирсон тохиолдолд түүний ар гэрийнхэнд нь даатгалын хамгаалалт үйлчлэхгүйгээс болж өндөр дүнтэй зээл төлөх санхүүгийн дарамт учирч, иргэд буруу ташаа ойлголттой болж, улмаар даатгалын үр нөлөө буурснаар ипотекийн зээлийн эко системд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Тодруулбал, үндэсний статистикийн хорооноос гаргасан тоон мэдээнээс нас баралтын тэргүүлэх шалтгаануудыг авч үзвэл 18 орчим хувийг гэнэтийн ослын эрсдэлийг багтаадаг гадны шалтгаант нас баралт эзэлдэг. Үүнээс харахад зээлдэгч нас барах, хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдах эрсдэлийн 18 орчим хувь нь даатгагдаж байгаа гэж ойлгож болно. Гэтэл цаана нь 80 гаруй хувийн эрсдэл даатгалгүй байна. Харин зээлдэгч нар урт хугацааны буюу амьдралын даатгалд даатгуулсан тохиолдолд аливаа шалтгааны улмаас даатгалын тохиолдол болоход нөхөн төлбөр авч болох буюу даатгалын хамгаалалтын хэмжээ 5–6 дахин нэмэгдэх боломжтой юм.

Ер нь ипотекийн зээл нь урт хугацааны санхүүгийн

бүтээгдэхүүн, үүнийгээ дагаад даатгалын гэрээ ч мөн урт хугацаатай байх шаардлагатайг олон улсын судалгаа, даатгалын зах зээлийн сайн жишгүүд бидэнд харуулж байна. Өөрөөр хэлбэл, орон сууцны ипотекийн урт хугацаат зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал нь урт хугацааны буюу амьдралын даатгалын бүтээгдэхүүн байх нь хамгийн тохиромжтой. Иймд ипотекийн зээлдэгч нар ямар эрсдэлээс даатгуулах нь зүйтэй вэ гэдгээ нарийн сайн тодорхойлсны үндсэн дээр даатгалын гэрээгээ байгуулах, цаашлаад даатгалын гэрээний нөхцөлүүдтэй маш сайн танилцаж байх шаардлагатай гэдгийг сануулъя.

Эцэст нь нэмж хэлэхэд, өнөө үед даатгал нь ирээдүй, хойч үеэ боддог, төлөвлөдөг, хамгаалдаг, санхүүгийн сахилга баттай хүмүүсийн зайлшгүй хийдэг далд хөрөнгө оруулалт гэж ойлгож болох юм. Даатгуулагчдын төлсөн даатгалын хураамжаар даатгагч нөөц сан бүрдүүлээд даатгуулагчдад хохирол учрахад нөхөн төлбөр олгоно, хохирол учрахгүй бол нөөц сангийн хөрөнгийг зохицуулагч байгууллагын хяналт дор бизнесийн санхүүжилт хэрэгцээтэй байгууллагуудад хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулдаг болохоос хүмүүсийн ярьдаг шиг хохиролд зарцуулаагүй үлдсэн хэсгийг нь даатгалын компанийн хувьцаа эзэмшигч нар хувааж идээд байдаггүй юм шүү дээ. Ер нь даатгалын компаниудын цуглуулсан даатгалын хураамжаас нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж, зуучлагчийн шимтгэл, нөөц сан, борлуулалт, үйл ажиллагааны гэх мэт зардлуудыг хасаад гарч буй үлдэгдэл нь үргэлж эерэг утгатай буюу ашигтай байдаггүй, харин тогтмол ашиг авчирдаг үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа байдаг гэдгийг дурдах нь зүйтэй байх.

Ярилцсанд баярлалаа.




ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ТОГТВОРТОЙ БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн тогтвортой бондын зах зээл 2023 онд 872 тэрбум ам.долларт хүрж өмнөх оноос 3 хувиар өсжээ. Тогтвортой бондын зах зээлийн голлох 4–н бүтээгдэхүүн болох ногоон бонд, нийгмийн бонд, тогтвортой байдлын бонд, тогтвортой байдалтай уялдсан бонд 2018 онтой харьцуулахад 4 дахин өссөн байна. Энэ нь хөрөнгө оруулагчдын байгаль орчин, нийгэмд ашигтай төслүүдийг санхүүжүүлдэг бондуудад хөрөнгө оруулах сонирхол жил бүр нэмэгдэж байгааг илтгэж байна.


Sustainable bond market

Global issuance, 2023: **\$872 billion**



Cumulative issuance since 2018: **\$4 trillion**

Эдгээр 4–н төрлийн тогтвортой бондууд нь тогтмол орлоготой үнэт цаас бөгөөд тогтвортой хөгжлийн зорилтыг хангах, байгаль орчин, нийгэмд чиглэсэн хөрөнгө оруулалтын төслүүдэд хөрөнгө оруулж санхүүгийн өгөөж хүртэх боломжийг хөрөнгө оруулагчдад олгодог. Ногоон бонд, нийгмийн бонд, тогтвортой байдлын бондууд нь тодорхой төслүүдийг санхүүжүүлэх, санхүүжилтийг үр ашигтай ашиглахад чиглэсэн байдаг. Харин тогтвортой байдалтай уялдсан бонд нь тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг (жишээлбэл, хүлэмжийн хий ялгаруулалтын бууралт) тусган, эдгээр зорилтуудын биелэлттэй уялдуулдаг.



Source: UNCTAD, based on information from Climate Bonds Initiative.

2023 оны байдлаар тогтвортой бондын зах зээлийн 587 тэрбум ам.долларыг ногоон бонд, 154 тэрбум ам.долларыг нийгмийн бонд, 109 тэрбум ам.доллларыг тогтвортой байдлын бонд, 22 тэрбум ам.доллларыг тогтвортой байдалтай уялдсан бонд тус тус бүрдүүлж байна.

- ◆ Ногоон бонд нь сэргээгдэх эрчим хүч, бохирдлоос урьдчилан сэргийлэх зэрэг байгаль орчинд ээлтэй төслүүдэд зориулан хөрөнгө босгох, үнэт цаас гаргагч нь хөрөнгийг хэрхэн зарцуулж байгаагаа ил тод тайлагнадаг онцлогтой.
- ◆ Нийгмийн бонд нь боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн гадуурхагдсан болон хүртээмж муутай бүлгүүд рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулах, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцжуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг нийгмийн томоохон асуудал руу чиглэсэн эерэг үр дүн авчрах төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэдэг. Нийгмийн бонд гаргагч нь хөрөнгийн зарцуулалт болон тухайн санхүүжүүлж буй төслийн үр дүнг хөрөнгө оруулагчдад ил тод нээлттэй тайлагнах үүрэгтэй бөгөөд ингэснээр хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын өгөөжийг тухайн төслийн нийгмийн үр шимээс харах бүрэн боломжтой.
- ◆ Тогтвортой байдлын бонд нь ногоон болон нийгмийн бондын шинжийг нэгтгэсэн ба байгаль орчин болон

нийгмийн үр ашиг руу чиглэсэн төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэдэг. Тогтвортой байдлын бондын хөрөнгийг сэргээгдэх эрчим хүч, ус хэмнэх, тогтвортой хөдөө аж ахуй, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцжуулалт, эрүүл мэндийн байгууламж зэрэг олон төрлийн төслүүдийг санхүүжүүлэхэд зарцуулдаг. Тус бонд нь Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн иж бүрэн төслүүдэд хөрөнгө оруулах хүсэлтэй хөрөнгө оруулагчдад зориулагдсан байдаг. Ногоон болон нийгмийн бондын адил тогтвортой байдлын бонд гаргагч хөрөнгийн зарцуулалт, санхүүжүүлсэн төслийн үр дүнг ил тод мэдээлж, гүйцэтгэлийг баталгаажуулан, тогтвортой байдлын зорилгуудтай нийцүүлэн хөрөнгө оруулагчдад тайлагнадаг.

- ◆ Тогтвортой байдалтай уялдсан бонд нь санхүүжилтийн зардлыг тогтвортой байдлын үндсэн үзүүлэлттэй нийцүүлдэг. Тогтвортой байдалтай уялдсан бонд нь ногоон болон нийгмийн, тогтвортой байдлын бондоос бүтэц болон зорилгын хувьд ялгаатай. Уламжлалт ногоон болон нийгмийн, тогтвортой байдлын бонд нь байгаль орчны болон нийгмийн үр ашиг руу чиглэсэн төслүүдэд төвлөрч эдгээр төслүүдийг шууд санхүүжүүлэх болон дахин санхүүжүүлдэг бол тогтвортой байдалтай уялдсан бонд нь гүйцэтгэлд суурилсан аргыг тодорхойлдог онцлогтой.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ТУЗ-ИЙН 2025 ОНД АНХААРАХ 5 СОРИЛТ


ТУЗ-ийн 2025 онд анхаарах чиглэлүүд

(Судалгаанд оролцогчид сайжруулах чиглэлийг "чухал" эсвэл "маш чухал" гэж хариулсан байна)


ТУЗ-ийн хяналт



ТУЗ-ийн үйл ажиллагаа



ТУЗ-удирдлагын багийн харилцаа



Эх сурвалж: 2025 оны NACD чиг хандлага ба тэргүүлэх чиглэлийн судалгаа, n=251

Дүгнэхэд, ТУЗ болон компаниуд нь нарийн төвөгтэй, тодорхойгүй, шинэ нөхцөл байдалд дасан зохицож ажиллахын тулд удирдлагын арга барилаа сайжруулах шаардлага үүсэж, харилцан адилгүй стратегийн бодлого, санал зөрөлдөөнөөс улбаатайгаар ТУЗ болон удирдлагын багийн хооронд ширүүн хэлэлцүүлэг өрнөж, шийдвэр гаргахад бэрхшээл учирч болзошгүй юм.

Судалгааны дүн болон ТУЗ-ийн гишүүдийн хариултаар дамжуулан NACD нь 2025 онд ТУЗ-д тулгарах таван сорилтыг тодорхойлсон бөгөөд ТУЗ-үүд компанийхаа нөхцөл байдалд тулгуурлан эдгээр сорилтыг даван туулах арга замыг сонгох боловч асуудал тус бүр дээр удирдлагын багтайгаа нягт хамтран ажилласнаар үр шимийг хүртэх боломжтой.

Сорилт 1: Хамгаалах эсвэл довтлох (эсвэл хослуулах)

Дэлхий даяар эдийн засгийн хамгаалах бодлого, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, геополитикийн тогтворгүй байдал нэмэгдэж байгаа нь ихэнх компаниудыг шинэ боломжийг эрэлхийлж, өндөр эрсдэлтэй зах зээл, бүс нутгаас зайлсхийхэд хүргэж байна. Үүний зэрэгцээ, технологийн хурдтай хөгжил, шинэ инновациуд нь уламжлалт бизнесийн загваруудыг эвдсэнээр зах зээлд өрсөлдөх тоглоомын шинэ дүрмүүдийг бий болгож, улмаар ТУЗ болон удирдлагын багуудад үүнд хэрхэн үр дүнтэйгээр оролцох вэ гэдэг сорилтыг бий болгож байна.

Ихэнх компаниудын хувьд өсөлтийн стратеги төлөвлөгөө өмнөх жилүүдээс тэс өөр болж байна. Жишээлбэл, Oliver Wyman (зөвлөх фирм)-ийн саяхны судалгаанд гүйцэтгэх

захирлуудын 40 гаруй хувь нь хангалттай хурдтай байж чадаагүйгээс өрсөлдөгчдийнхөө ард хоцрох нь AI-тай холбоотой хамгийн том эрсдэл гэж үзсэн байна. Иймд компаниуд 2025 онд AI-тай холбоотой хийсэн анхны туршилтуудыг даван гарч, үргэлжлүүлэн алсыг харж, түүнийг компанидаа өргөн цар хүрээтэй ашиглахын тулд томоохон хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна гэжээ.

Шинэчлэгдэж буй технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр компаниудад нэмүү өртөг бий болгох боломж нээгдэж байгаа ч нөгөө талаас түүнийг хариуцлагатайгаар ашиглах нь хэрэглэгчдийн итгэлийг олж авахад чухал үүрэг гүйцэтгэх төлөвтэй байна. Өнөөгийн байдлаар технологийн ашиглалтад итгэх итгэлийн түвшин харьцангуй бага байна. Edelman Trust Barometer-ийн 2024 онд хийсэн судалгаанд оролцогчдын ердөө 59 хувь нь инновацыг нэвтрүүлэх ажлыг үр дүнтэй удирдана гэдэгт итгэж байна гэж хариулжээ. Түүнчлэн, бизнест итгэх итгэл, тодорхой төрлийн технологид итгэх итгэл хоёрын хооронд зөрүүтэй, тухайлбал, судалгаанд оролцогчдын 76 хувь нь технологийн компаниудын үйлдлийг зөв гэж үзэж байгаа бол AI технологид итгэх итгэл 50 хувь байна.

Ирэх онд технологийн хөрөнгө оруулалтын боломжит цар хүрээ, стратегийн ач холбогдлыг авч үзэхдээ хувьцаа эзэмшигчид, үйлчлүүлэгчид болон олон нийтийн итгэлийг тооцоолохгүй байж болохгүй бөгөөд ТУЗ-ийн хувьд дээр дурдсан хөгжил шинэчлэл болон итгэлийг хамгаалах хоёрын тэнцвэрийг хадгалах шаардлага үүсэж байна.

Богино хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай шинэ санаанууд болон томоохон өөрчлөлтүүдийг нэгэн зэрэг удирдан зохион байгуулах тохиолдолд ТУЗ нь хэзээ "хамгаалагч" (итгэлийг хадгалах) байх эсвэл "хурдасгагч" (удирдлагыг илүү их эрсдэл хүлээхийг шаардах) байх сонголтыг хийхээ маш нухацтай тунгаах ёстой.

Анхаарах зүйлс

ТУЗ-д эрсдэлээс зайлсхийх болон эрсдэлтэй алхам хийх аль аль тохиолдолд дараах зөвлөмжийг NACD өгч байна:

- ◆ ТУЗ нь шийдвэр гаргах явцыг удирдан чиглүүлэх зорилгоор эрсдэл хүлээх чадварын хүрээг боловсруулан тодорхойлох шаардлагатай боловч гол анхаарах асуудал нь зөвхөн хүлээн зөвшөөрөх боломжтой хамгийн дээд эрсдэлийг тогтоохдоо

бус, харин ТУЗ-д ямар нөхцөлд эрт сэрэмжлүүлэх дохиолол (early warning signals)-уудыг мэдээлэх, мөн инновацын шинжтэй хөрөнгө оруулалтын үр дүнг хэмжихэд ямар үзүүлэлтүүдийг ашиглах талаар тодорхой зөвшилцөлд хүрэх явдал юм.

- ◆ ТУЗ удирдлагын багтай хамтран эрсдэл болон стратегийн чухал асуудлуудыг цогц байдлаар хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Үр дүнтэй хэлэлцүүлэг явуулахын тулд тасралтгүй хяналт, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх үүднээс гүйцэтгэх удирдлагаас гаргадаг эрсдэлийн тайланг тогтмол хугацаанд хянаж, эрсдэлийн хэв шинжийг цаг хугацаа болон байршлын хувьд шинжилж чадаж байгаа эсэхийг нягтлах шаардлагатай.
- ◆ ТУЗ оролцогч талуудын итгэлийг технологийн шийдвэр гаргалтын нэг хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч, шинэ технологийг хөгжүүлж, ашиглахдаа компанийн зорилго, үнэт зүйлсийн талаарх бодол санааг нэгтгэх зорилгоор удирдлагын багтай хамтран ажиллах ёстой.
- ◆ Бизнесийн тасралтгүй байдал, гэнэтийн эрсдэлийн төлөвлөгөөнд тогтмол хяналт тавьж, турших хэрэгтэй бөгөөд уг төлөвлөгөө нь геополитикийн тогтворгүй байдалд үзүүлэх хариу арга хэмжээ зэрэг олон хувилбаруудыг багтаасан байх ёстой. Эрсдэлийн менежментийн тогтмол хяналт, туршилт нь хүндрэлтэй нөхцөл байдлын үед хямралд оруулах мэдээллийн буруу урсгал, харилцааны хурцадмал байдлаас урьдчилан сэргийлж, илрүүлж чадна.
- ◆ ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын багийг уулзалт, хэлэлцүүлэгт оролцуулж, бизнесийн чиглэл, ирээдүйн талаар санал бодлыг нь сонсох хэрэгтэй. Эрсдэлийг бууруулахын тулд хууль эрх зүй, нийцлийн болон аудитын удирдлагуудын саналыг сонсохоос гадна ерөнхий менежерүүд болон нэгжийн удирдагчдын саналыг сонсох нь чухал юм.

Үргэлжлэл бий..

Эх сурвалж: www.nacdonline.org

ФИНТЕК БА РЕГТЕК

ФИНТЕК БА РЕГТЕК ДЭХ ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ (AI) ХЭРЭГЛЭЭ

Эхлэл нь 1-р нүүрт



Нөгөөтэйгүүр санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хиймэл оюун ухаан нь чатбот болон виртуал туслах хэлбэрээр финтек орчинд ашиглагдаж байна. Тодруулбал, KAI (Kasisto), Erica

(Bank of America) зэрэг хиймэл оюун ухаанд суурилсан санхүүгийн туслахууд нь хэрэглэгчдэд санхүүгээ удирдахад нь тусалж, банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах, хэрэглэгчдэд 24/7 үйлчлэх боломжийг олгож байна.

Регтек дэх хиймэл оюун ухаан

Хиймэл оюун ухаан нь зохицуулалтын нийцлийг автоматжуулж, алдааг багасган, зардлыг бууруулахад чиглэж, регтекийн хөгжлийг дараагийн түвшинд хүргэж байна. Хиймэл оюун ухааны регтек дэх хэрэглээний нэг бол зохицуулалтын тайланг автоматжуулах юм. Санхүүгийн байгууллагууд олон төрлийн дүрэм, журмыг дагаж мөрдөх шаардлагатай байдаг бөгөөд хиймэл оюун ухаанд суурилсан шийдлүүд нь өгөгдөл цуглуулах, баталгаажуулах, тус тайлагнах процессыг автоматжуулахад тусалдаг. Жишээ нь, Ascent компани хиймэл оюун ухаан ашиглан зохицуулалтын өөрчлөлтүүдийг хянаж, санхүүгийн байгууллагууд зохицуулалтын шаардлагыг хангаж ажиллахад тусалдаг.

Мөн гүйлгээний хяналт ба мөнгө угаахтай тэмцэх (AML) үйл ажиллагаа нь хиймэл оюун ухааны ачаар сайжирсаар байна. Уламжлалт дүрэмд суурилсан системүүдийн хувьд санхүүгийн байгууллагууд нөөц их зарцуулах, гар ажиллагаа шаардагдах, цаг хугацаа алдах зэрэг дутагдалтай байсан бол өдгөө Ayasdi, Feedzai зэрэг хиймэл оюун ухаанд суурилсан платформуудын тусламжтай машин сургалтыг ашиглан мөнгө угаах гэмт хэргийн илрүүлэлтийг оновчтой болгож, бодит эрсдэлийг илүү нарийвчлалтай илрүүлэх, зардлыг бууруулах зэргээр регтекийг сайжруулсаар байна.

Мөн хиймэл оюун ухаан нь зохицуулалтын орчны

эрсдэлийн үнэлгээг сайжруулж, их өгөгдлийг шинжлэн зохицуулалтын нийцтэй байдлын эрсдэлийг урьдчилан таамаглахад тусалдаг бөгөөд эх хэлний боловсруулалт (NLP)-ыг ашиглан зохицуулалтын баримт бичгүүдийг шинжлэн холбогдох мэдээллийг ялгаж, санхүүгийн байгууллагуудад дүрэм журмын өөрчлөлтөд урьдчилан бэлтгэх боломж олгож байна.

Хиймэл оюун ухааны финтек ба регтек дэх хэрэглээний жишээнүүд:

Дэлхийн томоохон санхүүгийн байгууллагууд болон технологийн компаниуд хиймэл оюун ухааныг ашиглан финтек, регтекийн шийдлүүдийг хөгжүүлж байна:

“JPMorgan Chase & Co” компанийн гэрээний ухаалаг шинжилгээний (COiN) платформ нь хиймэл оюун ухааныг ашиглан хууль эрх зүйн баримт бичгийн дүн шинжилгээг хурдасгаж, санхүүгийн байгууллагуудын үр ашгийг нэмэгдүүлж буй шилдэг жишээ юм. Тус платформ нь машин сургалтыг ашиглан гэрээний гол заалтуудыг таньж, эрсдэлийг тодорхойлох замаар уг үйл явцыг автоматжуулдаг. Энэхүү платформ нь 12,000 гаруй арилжааны зээлийн гэрээг хэдхэн секундийн дотор боловсруулж, хүний гар ажиллагааг багасгахын зэрэгцээ алдааг бууруулж, байгууллагуудыг илүү стратегийн үйл ажиллагаанд төвлөрөх боломжтой болгож байна.

HSBC компанийн Динамик эрсдэлийн үнэлгээ (DRA) нь үүлэн технологид суурилсан систем бөгөөд мөнгө угаах эрсдэлийг илрүүлэх, удирдахад хиймэл оюун ухааныг ашигладаг. Динамик эрсдэлийн үнэлгээний систем нь банкны бодит өгөгдөл дээр сургагдсан загваруудаар хэрэглэгч, данс, гүйлгээний мэдээллийг түүхэн болон бодит цагийн горимоор боловсруулж, эрсдэлийн үнэлгээг сайжруулдаг.

Wealthfront бол хиймэл оюун ухааныг ашиглан санхүүгийн мэдээллийг шинжлэх, хөрөнгө оруулалтын шийдвэрийг



оновчтой гаргахад тусалдаг тэргүүлэгч робо-зөвлөх платформ юм. Энэхүү систем нь 440,000 гаруй хэрэглэгч, 25 тэрбум ам.долларын хөрөнгийг

удирддаг бөгөөд хиймэл оюун ухааны алгоритмуудыг ашиглан хөрөнгө оруулалтын багцыг оновчтой удирдах, санхүүгийн тайлан гаргах, хэрэглэгчдэд тохирсон хөрөнгө оруулалтын стратегийг боловсруулахад чиглэсэн үйлчилгээ үзүүлдэг. Үүнээс гадна үйлчилгээний хураамж нь 0.25%, гүйлгээний хураамжгүй тул санхүүгийн зах зээлд илүү хямд, хүртээмжтэй, ухаалаг шийдлийг санал болгож байна.



Kasisto компанийн KAI платформ нь эх хэлний боловсруулалт ашиглан банк, санхүүгийн салбар дахь хэрэглэгчийн харилцааг сайжруулдаг хиймэл оюун ухаанд суурилсан харилцагчийн үйлчилгээний шийдэл юм. Энэхүү хиймэл оюун ухаант чатбот нь банкны үйлчлүүлэгчдэд санхүүгийн зөвлөгөө өгч, өөртөө үйлчлэх боломжийг олгосноор харилцагчийн үйлчилгээний төвүүдийн ачааллыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Нөгөөтээгүүр KAI нь хэрэглэгчдийн асуултыг ойлгон хариулах, санхүүгийн шийдвэр гаргахад нь туслах чадвартай.

Эх сурвалж: startuphub

Ирээдүйн чиг хандлага

Хиймэл оюун ухаан нь санхүүгийн салбарт хувьсгал хийж, бизнесийн үйл ажиллагааг хурдасгах, хэрэглэгчийн үйлчилгээний түвшнийг дээшлүүлэх, зохицуулалтын

нийцлийг сайжруулах чухал хүчин зүйл болсоор байна. Санхүүгийн байгууллагууд хиймэл оюун ухаанд суурилсан технологийг хөгжүүлснээр автоматжуулсан шийдлүүдийг ашиглан илүү үр дүнтэй эрсдэлийн удирдлага, залилангийн илрүүлэлт, үйл ажиллагааны оновчлолыг хэрэгжүүлж байна.

Хиймэл оюун ухааны санхүүгийн салбар дахь хэрэглээг авч үзвэл ойрын ирээдүйд түүний санхүүгийн салбар дахь үүрэг улам бүр нэмэгдэхээр байна. Тодруулбал, Дэлхийн эдийн засгийн форумын "Санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухаан 2025" тайланд жижиг хэлний загварууд (SLM), хиймэл оюун ухааны агентууд, квант тооцоолол зэрэг технологиудын хөгжлийг даган санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ улам нарийсаж, илүү өндөр түвшинд хүрэх хандлагатай байгааг дурдсан. Цаашилбал, хиймэл оюун ухааны тусламжтайгаар зээлийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт, гүйлгээний хяналт зэрэг олон чухал үйл ажиллагааг автоматжуулах боломж нэмэгдэхээр байна. Түүнчлэн хиймэл оюун ухааны дэвшилтэт загварууд нь зөвхөн автоматжуулалтаар хязгаарлагдахгүй бөгөөд санхүүгийн зөвлөгөө, хөрөнгө оруулалтын удирдлага, хэрэглэгчийн зан төлөвийн дүн шинжилгээ зэрэг олон чиглэлд томоохон ахиц гаргах боломжтой.

Хиймэл оюун ухааныг стратегийн түвшинд ашиглах нь санхүүгийн байгууллагуудын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, илүү тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн экосистемийг бүрдүүлэх үндэс суурь болох ч үүний хөгжлийг даган гарах өгөгдлийн хамгаалалт, ёс зүйн асуудлууд зэрэг зохицуулалтын хүрээнд үүсэх сорилтуудыг мөн оновчтой шийдэх шаардлага үүсэж байна.

Эх сурвалж:

- ◆ DigitalDefynd, T. (2024, November 30). 5 ways JP Morgan is using AI – Case Study [2025] – DigitalDefynd. DigitalDefynd. <https://digitaldefynd.com/IQ/jp-morgan-using-ai-case-study/>
- ◆ Katkov, N. (2023, June 16). HSBC: Cloud-Based Financial Crime Detection at Scale. Celent. <https://www.celent.com/insights/486588421>, https://services.google.com/fh/files/misc/hsbc_celent_model_risk_manager_of_the_year_2023.pdf
- ◆ Wadhvani, K. (2025, January 3). *AI in Fintech: Top 4 Use Cases and Case Study*. Blockchain Technology, Mobility, AI and IoT Development Company USA, Canada. https://www.solulab.com/ai-in-fintech/#elementor-toc_heading-anchor-15
- ◆ World economic forum. (2025, January) "Artificial Intelligence in Financial Services" report. <https://www.weforum.org/reports/artificial-intelligence-in-financial-services-2025>

СУДЛААЧИЙН ИНДЭР

УЛС ОРНУУДЫН МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТОГТООСОН ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ДЭЭД ХЯЗГААРЫГ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хороо, банк бус санхүүгийн байгууллагын газрын Мөнгөн зохицуулалтын алба

УЛС ОРНУУДЫН МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТОГТООСОН ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ДЭЭД ХЯЗГААРЫГ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Дэлхий дээр зээлийн хүүгийн дээд хэмжээнд хязгаар тогтоосон ойролцоогоор 60–80 улс орон байдаг гэх судалгаа, мэдээлэл байх боловч энэ төрлийн тоон мэдээллийг нарийн тогтоох нь хүндрэлтэй байдаг байна. Учир нь улс орон бүр өөрийн хууль эрх зүйн орчин, санхүүгийн зохицуулалт, эдийн засгийн чадамж, хэрэглэгчийн зан төлөв, соёл гэх зэрэг олон хүчин зүйлээс хамаарч төрөл бүрийн хязгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдаг бөгөөд эдгээр нь өөр өөр механизмаар хэрэгждэг байна. Иймд зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоосон байдлыг бүс нутгаар бүлэглэн судлах нь илүү оновчтой байж болох тул доорх судалгаанд 2024 оны байдлаарх улс орнуудын тогтоосон зээлийн хүүгийн хязгаарыг бүс нутгаар бүлэглэн авч үзэв.

ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛС ОРНУУД

Европын Холбооны 20 гаруй улс зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоодог боловч хэрэгжүүлэх арга зам нь ялгаатай байна. Харин улс орнуудын бодлогын хүү буюу суурь хүүг European Central Bank-с тогтоож өгдөг бөгөөд бодлогын хүүгийн хувь хэмжээ ижил тогтоогддог байна.

ХБНГУ¹: Германы Иргэний хуулийн (German Civil Code) дагуу зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоодог бөгөөд жилд хоёр удаа шинэчилдэг байна.

Суурь хүү + 2 % → 5.15%

Франц улс²: Францын Төв Банк (Banque de France) хүүгийн дээд хязгаарыг улирал бүр шинэчлэн тогтоож албан ёсны сэтгүүлд нийтэлдэг. Энэ хязгаар нь зээлийн төрөл, хугацаанаас хамаарч өөр өөр байдаг. Энэ нь жилийн нэрлэсэн хүү (nominal interest rate) болон заавал төлөх зардлуудыг (холбогдох шимтгэл, даатгал гэх мэт) хамруулсан нийт хүүгийн түвшинд суурилдаг

Өмнөх гурван сарын дундаж хүү дээр гуравны нэгийг (1/3) нэмэх замаар тооцно.

2024 оны 10 дугаар сарын байдлаарх зээлийн хүүгийн дээд хязгаар:

10 хүртэлх жилийн хугацаатай тогтмол хүүтэй зээл → 4.63%

20 ба түүнээс дээш жилийн хугацаатай тогтмол хүүтэй зээл → 5.85%

Хувьсах хүүтэй зээл → 5.99%

¹ <https://www.gesetze-im-internet.de/german-civil-code-bgb>

² <https://www.banque-france.fr>

Португал улс³: Зээлийн хүүгийн дээд хязгаарыг Португалийн Иргэний хууль болон сайд нарын тушаалаар тогтоодог. Энэ хязгаар нь зээлийн барьцаатай эсэхээс хамаарч өөрчлөгддөг.

Барьцаат зээл (secured loans): Суурь хүү + 3% → 6.15%
 Барьцаагүй зээл (unsecured loans): Суурь хүү + 5% → 8.15%

Торгуулийн (дефолт) хүүгийн хязгаар

Барьцаат зээл (secured loans): Суурь хүү + 7%
 Барьцаагүй зээл (unsecured loans): Суурь хүү + 9%

Европын орнуудын зээлийн хүүгийн хязгаар тогтоосон байдал нь гол төлөв суурь хүү дээр тодорхой хувь хэмжээг нэмж тооцох, тэр дундаа барьцаагүй зээлд барьцаат зээлээс илүү хувь хэмжээ нэмж тооцох зарчмыг баримталсан байна.

2024 оны байдлаар дараах улс орнуудад хэрэгжиж буй зээлийн хүүгийн дээд хязгаараас инфляцын түвшинг хасаж тооцоход дундаж бодит хүү 4.06%, суурь хүү дээр нэмсэн дундаж эрсдэлийн шагнал 3.28%, банкны хүүг дунджаар 1.38 дахин нэмэгдүүлэх замаар зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоосон байна.

Улсын нэр	Суурь хүү	Банкны зээлийн хүү	Хүүгийн дээд хязгаар	Инфляц	Бодит хүү	Эрсдэлийн шагнал	Хүүгийн дээд хязгаар/ Банкны хүү
A	B	C	D	E	D-E	D-B	D/C
Герман	3.15%	4.98%	5.15%	2.80%	2.35%	2.00%	1.03
Франц	3.15%	4.48%	5.99%	1.30%	4.69%	2.84%	1.34
Португал	3.15%	4.62%	8.15%	3.00%	5.15%	5.00%	1.76
Ave	3.15%	4.69%	6.43%	2.37%	4.06%	3.28%	1.38
Median	3.15%	4.62%	5.99%	2.80%	4.69%	2.84%	1.34
Stdev	0.00%	0.26%	1.55%	0.93%	1.50%	1.55%	0.37
Max	3.15%	4.98%	8.15%	3.00%	5.15%	5.00%	1.76
Min	3.15%	4.48%	5.15%	1.30%	2.35%	2.00%	1.03

АЗИЙН УЛС ОРНУУД

БНСУ⁴: Өмнөд Солонгос дахь зээлийн хүүгийн дээд хязгаарыг тодорхойлох үндсэн баримт бичиг нь Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хууль (금융소비자보호에 관한 법률) юм. Тус хуулийн дагуу 2021 оны 7 дугаар сараас эхлэн боломжит хүүгийн дээд түвшинг жилд 20% тогтоосон. Энэ хууль нь хүүгийн дээд түвшинг тодорхойлж, хэт өндөр хүүгээс хэрэглэгчийг хамгаалах, зах зээлд шударга, ил тод ажиллагааг хангах зорилготой юм. Энэ хууль болон хүүгийн хязгаарлалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг Солонгосын Санхүүгийн үйлчилгээний хороо (Financial Services Commission) хэрэгжүүлдэг.

Хүүгийн хязгаарлалт нь хэрэглээний зээл, хэрэглэгчийн зээл, жижиг бизнесийн зээл зэрэг олон төрлийн зээлд хамаарна.

³ ms.invoicemaker.com/Portugal-Law-And-Practice-Section-4.3-Usury-Laws

⁴ https://www.fsc.go.kr

Тайланд⁵: Зээлийн хүүгийн дээд хязгаарыг Тайландын хуулиар тогтоож Тайландын Банк (BOT) хэрэгжүүлдэг. Тайланд улсад зээлийн хүүгийн дээд хязгаар одоогоор жилд 15% тогтоогдсон бөгөөд энэ хязгаар нь иргэдийн болон арилжааны зээлд хамаарна.

Вьетнам улс⁶: Вьетнамын Иргэний хуульд зээлийн хүүгийн дээд хязгаарыг жилд 20% гэж заасан байдаг боловч банк, санхүүгийн компаниуд гэх мэт зээлийн байгууллагуудаас олгож буй зээл энэ хязгаарт хүрдэггүй байна.

Вьетнам дахь жишиг хүү 2024 оны сүүлээр 4.50% байсан. Харин 2000– 2024 оны хооронд зээлийн жишиг хүү дунджаар 6.67%–тай байсан бол 2008 оны 6 дугаар сард 15.00% болж бүх цаг үеийн дээд хэмжээнд хүрч байсан байна.

Камбож улс: Камбожийн Үндэсний банк (NBC) бичил санхүүгийн зээлийн хүүгийн дээд хязгаарыг (банк, бичил зээл MFI, бичил хуримтлал MDI) тогтоодог бол Хууль зүйн яам бусад зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоодог. Хууль зүйн яам хүүгийн дээд хэмжээг жилийн 10% – 30%

хүртэл тогтоож болох боловч одоогоор Хууль зүйн яамны хүү жилийн 18% байна.

Шри Ланк улс⁷: Шри Ланкийн Төв банкнаас 2023 оны 8 дугаар сард барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны жилийн хүүгийн дээд хязгаарыг 18% байхаар тогтоосон байна. Хязгаарлалтын зорилго нь зээлдэгчдийг тодорхой төрлийн зээлийн хэт өндөр хүүгээс хамгаалах.

Азын улс орнууд зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоохдоо хувьсагчгүй тогтмол нэрлэсэн хүүг зарласан байх бөгөөд энэ хязгаар нь банкнаас бусад санхүүгийн байгууллагууд болон хувь хүний зээл, зээлийн картад хамаардаг байна.

2024 оны байдлаар Азийн улс орнуудад хэрэгжиж буй зээлийн хүүгийн дээд хязгаарт шинжилгээ хийхэд инфляцын түвшинг хасаж тооцсон дундаж бодит хүү 15.86%, суурь хүү дээр нэмсэн дундаж эрсдэлийн шагнал 14.35%, банкны хүүг дунджаар 3.10 дахин нэмэгдүүлэх замаар зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоосон байна.

Улсын нэр	Суурь хүү	Банкны зээлийн хүү	Хүүгийн дээд хязгаар	Инфляц	Бодит хүү	Эрсдэлийн шагнал	Хүүгийн дээд хязгаар/ Банкны хүү
A	B	C	D	E	D-E	D-B	D/C
БНСУ	3.00%	4.64%	20.00%	1.90%	18.10%	17.00%	4.31
Тайланд	2.25%	7.03%	15.00%	0.40%	14.60%	12.75%	2.13
Вьетнам	3.00%	5.06%	20.00%	2.94%	17.06%	17.00%	3.95
Камбож	3.00%	5.80%	18.00%	1.46%	16.54%	15.00%	3.10
Шри Ланк	8.00%	9.06%	18.00%	5.00%	13.00%	10.00%	1.99
Ave	3.85%	6.32%	18.20%	2.34%	15.86%	14.35%	3.10
Median	3.00%	5.80%	18.00%	1.90%	16.54%	15.00%	3.10
Stdev	2.34%	1.78%	2.05%	1.74%	2.04%	3.00%	1.04
Max	8.00%	9.06%	20.00%	5.00%	18.10%	17.00%	4.31
Min	2.25%	4.64%	15.00%	0.40%	13.00%	10.00%	1.99

⁵ Thailand Lawyer | Thailand Law Library

⁶ <https://vietnamlawmagazine.vn/civil-code-vietnamese>

⁷ Monetary board, Central bank of Sri Lanka, Monetary Law Act Order (2023.08.25)

АМЕРИКИЙН БҮС НУТАГ, АВСТРАЛИ

Америкийн нэгдсэн улс: АНУ–ын зээлийн хүүгийн хязгаар нь мужаас хамаарч өөр өөр байдаг. Зарим мужид хүүгийн дээд хэмжээ байдаг бол зарим мужид дээд хязгаар тогтоогоогүй байдаг. Одоогоор 19 мужид (DC) богино хугацааны зээлд жилийн 36% хүүгийн дээд хязгаар тогтоогоод байна.

Канад¹: 2025 оны эхний байдлаар Канадад зээлийн хүүгийн дээд хязгаар жилийн 35% байна (APR). Энэ хязгаар нь зээлтэй холбоотой бүх шимтгэл, зардал, хүүд хамаарна. Канадын төв банкнаас (The Bank of Canada) эмзэг зээлдэгчдийг хамгаалах зорилгоор зээлийн хүүгийн дээд хязгаарыг 47.9%–иас 35% болгон бууруулсан бөгөөд энэхүү хязгаар нь 10,000 доллар ба түүнээс доош хэмжээний зээлд хамаарна.

Чили улс: Чили улсад зээлийн хүүгийн дээд хязгаарыг 2013 онд хуулиар тогтоосон бөгөөд хэрэглээний зээлийн хүүгийн дээд хязгаарыг 54%–иас 36% болгон бууруулж тогтоожээ. Энэ хязгаар нь тус улсын бүх хэрэглээний зээл, тэр дундаа банкуудад хамаарна.

Австрали улс: 2009 оны Хэрэглэгчийн зээлийг хамгаалах үндэсний хуулиар (NCCP) хэрэглээний зээлийн хүүгийн дээд хязгаарыг 48% тогтоосон бөгөөд энэ нь зээлийн

нийт зардал, бүх шимтгэл, хураамжийг оруулаад жилийн 48%–иас хэтрэхгүй.

Америкийн бүс нутаг болон Австрали зэрэг өндөр хөгжилтэй улс орнууд зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоохдоо хувьсагчгүй тогтмол нэрлэсэн хүүг зарласан байх бөгөөд энэ хязгаар нь зээлийн нийт зардал, бүх шимтгэл, хураамжийг багтаасан байхаар заасан байна. Зээлийн хүүгийн дээд хязгаар нь хэрэглээний зээл болон 10,000 доллар ба түүнээс доош хэмжээний зээлд хамаарч байна.

2024 оны байдлаар Америкийн бүс нутаг болон Австрали зэрэг өндөр хөгжилтэй улс орнуудад хэрэгжиж буй зээлийн хүүгийн дээд хязгаарт шинжилгээ хийхэд инфляцын түвшинг хасаж тооцсон дундаж бодит хүү 35.85%, суурь хүү дээр нэмсэн дундаж эрсдэлийн шагнал 34.54%, банкны хүүг дунджаар 4.75 дахин нэмэгдүүлэх замаар зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоосон байна.

Улсын нэр	Суурь хүү	Банкны зээлийн хүү	Хүүгийн дээд хязгаар	Инфляц	Бодит хүү	Эрсдэлийн шагнал	Хүүгийн дээд хязгаар/ Банкны хүү
A	B	C	D	E	D-E	D-B	D/C
АНУ	4.25%	7.50%	36.00%	2.90%	33.10%	31.75%	4.80
Канад	3.25%	5.20%	35.00%	1.80%	33.20%	31.75%	6.73
Чили	5.00%	9.20%	36.00%	4.50%	31.50%	31.00%	3.91
Австрали	4.35%	13.49%	48.00%	2.40%	45.60%	43.65%	3.56
Ave	4.21%	8.85%	38.75%	2.90%	35.85%	34.54%	4.75
Median	4.30%	8.35%	36.00%	2.65%	33.15%	31.75%	4.36
Stdev	0.72%	3.50%	6.18%	1.16%	6.55%	6.09%	1.42
Max	5.00%	13.49%	48.00%	4.50%	45.60%	43.65%	6.73
Min	3.25%	5.20%	35.00%	1.80%	31.50%	31.00%	3.56

МОНГОЛ УЛСТАЙ ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАМЖААР ОЙРОЛЦОО УЛС ОРНУУД

Нэг хүнд ногдох ДНБ, хүн амын тоо, эдийн засгийн бүтцийн ойролцоо байдал, бүс нутгийн байрлал, хөгжлийн түвшин зэргийг харгалзан үзэж дараах улс орнуудыг Монгол улстай эдийн засгийн чадамжийн хувьд ойролцоо орноор тодорхойлов. Эдгээр орнууд бүгд жижиг, хүн амын тоо хязгаарлагдмал бөгөөд экспортод тулгуурласан эдийн засагтай, уул уурхай, хөдөө аж ахуйгаас өндөр хамааралтай, эдийн засгийн хөгжил нь дунд болон доод түвшинд тооцогддог байна. Ялангуяа Киргизстан улс нь эдийн засгийн бүтэц, хөгжил болон хүн амын тоо зэрэг үзүүлэлтээр Монгол Улстай хамгийн ойролцоо байна.

Улсын нэр	ДНБ (2023 он)	Хүн ам	Эдийн засаг
Монгол	~16–18 тэрбум ам.доллар	~3.5 сая	Уул уурхай, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбар дээр голчлон тулгуурладаг
Киргизстан	~10 тэрбум ам.доллар	~7 сая	Хөдөө аж ахуй, алт олборлолтод суурилдаг бөгөөд уул уурхайн салбар ихээхэн нөлөөтэй
Гүрж	~25 тэрбум ам.доллар	~3.7 сая	Эдийн засгийн бүтэц нь жижиг боловч экспортод тулгуурласан (дарс, газар тариалан, аялал жуулчлал).
Армени	~20 тэрбум ам.доллар	~3 сая	Уул уурхай, мэдээллийн технологи, хөдөө аж ахуйд тулгуурласан эдийн засагтай.

Киргизстан: Бүгд Найрамдах Киргизстан улсын Зээлийн хүүгийн үйл ажиллагааг хязгаарлах тухай хуулийн дагуу Үндэсний банкнаас (National Bank of the Kyrgyz Republic) банкны зээлийн дундаж жигнэсэн нэрлэсэн хүү дээр 15% нэмж тооцно. Киргизстан улсын хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн нэмэлт хураамж, шимтгэл болон бусад төлбөр авах боломжгүй.

Гүрж: Гүржид Банк санхүүгийн газар (Department of Banking and Finance) нь Гүржийн хэсэгчилсэн зээлийн тухай хуулийн дагуу зээлийн хүүгийн дээд хязгаарт хяналт тавин ажилладаг. Энэ хуулийн дагуу 3,000 ам.доллар ба түүнээс доош зээлийн хүүг хязгаарладаг.

- ◆ 3,000 ам.доллар ба түүнээс бага зээлийн хүү нь жилийн 16% –иас хэтрэхгүй;
- ◆ Бичгээр гэрээ байгуулаагүй зээлийн хүү 7%–иас хэтрэхгүй;

Цэргийн зээлийн хууль (MLA) нь цэргийн жинхэнэ алба хааж байгаа гишүүд болон тэдний хамааралтай хүмүүсийн зээлийн хүүг 36% хүртэл хязгаарладаг.

Армени: Бүх санхүүгийн байгууллагуудын зээлийн хүүгийн дээд хязгаарыг Арменийн Иргэний хуульд заасан бөгөөд Арменийн Төв банк (The Central Bank of Armenia) хяналт тавин ажилладаг. Арменийн зээлийн хүүгийн дээд хязгаарыг банкны хүүгээс хоёр дахин нэмэгдүүлж тооцохоор заасан байдаг бөгөөд одоогийн байдлаар

зээлийн хүүгийн дээд хэмжээг 24%–иар хязгаарлаж байна.

Эдийн засгийн хөгжлөөр манай улстай ойролцоод тооцогдох Киргизстан, Армени гэх улсууд зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоохдоо арилжааны банкны дундаж хүүг гол хувьсагч болгон авч түүн дээр 12%–15% хувийн хүү нэмж тооцох аргачлалыг баталсан байна.

Киргизстан, Армени, Гүрж улсад 2024 оны байдлаар хэрэгжиж буй зээлийн хүүгийн дээд хязгаарт шинжилгээ хийхэд инфляцын түвшинг хасаж тооцсон дундаж бодит хүү 21.17%, суурь хүү дээр нэмсэн дундаж эрсдэлийн шагнал 16.43%, банкны хүүг дунджаар 1.55 дахин нэмэгдүүлэх замаар зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоосон байна.

Улсын нэр	Суурь хүү	Банкны зээлийн хүү	Хүүгийн дээд хязгаар	Инфляц	Бодит хүү	Эрсдэлийн шагнал	Хүүгийн дээд хязгаар/ Банкны хүү
					J=D-E	H=D-B	I=D/C
A	B	C	D	E	J	H	I
Киргизстан	9.00%	18.30%	33.30%	6.30%	27.00%	24.30%	1.82
Гүрж	8.00%	15.65%	16.00%	2.00%	14.00%	8.00%	1.02
Армени	7.00%	13.17%	24.00%	1.50%	22.50%	17.00%	1.82
Ave	8.00%	15.71%	24.43%	3.27%	21.17%	16.43%	1.55
Median	8.00%	15.65%	24.00%	2.00%	22.50%	17.00%	1.82
Stdev	1.00%	2.57%	8.66%	2.64%	6.60%	8.16%	0.46
Max	9.00%	18.30%	33.30%	6.30%	27.00%	24.30%	1.82
Min	7.00%	13.17%	16.00%	1.50%	14.00%	8.00%	1.02

Судалгаанд хамрагдсан улс орнууд зээлийн хүүгийн дээд хязгаарыг жилийн 5.15% – 48% –иар тогтоосон байх бөгөөд өндөр хөгжилтэй орнууд нэлээд өндөр тогтоох хандлагатай буюу жилийн 35% – 48%, европын холбооны орнууд 5.15% – 8.15%, Азийн улс орнууд 15.00% – 20.00%, Монгол Улстай эдийн засгийн чадамжаар ойролцоо улс орнууд 16.00% – 33.00% –иар тогтоосон байна.

Инфляцын түвшинг хассан бодит хүүгийн хувь хэмжээ 2.35% – 45.6% байгаа бол суурь хүү (бодлогын хүү) дээр нэмэгдүүлсэн эрсдэлийн шагнал 2.00% – 43.65% байна. Харин арилжааны банкны зээлийн хүүг хамгийн багадаа 1.02 дахин нэмэгдүүлж, хамгийн ихдээ 6.73 дахин нэмэгдүүлсэн байна.

Улсын нэр		Суурь хүү	Банкны зээлийн хүү	Хүүгийн дээд хязгаар	Инфляц	Бодит хүү	Эрсдэлийн шагнал	Хүүгийн дээд хязгаар/ Банкны хүү
A		B	C	D	E	D-E	D-B	D/C
Европын холбооны улсууд	Ave	3.15%	4.69%	6.43%	2.37%	4.06%	3.28%	1.38
	Max	3.15%	4.98%	8.15%	3.00%	5.15%	5.00%	1.76
	Min	3.15%	4.48%	5.15%	1.30%	2.35%	2.00%	1.03
Азийн улс орнууд	Ave	3.85%	6.32%	18.20%	2.34%	15.86%	14.35%	3.1
	Max	8.00%	9.06%	20.00%	5.00%	18.10%	17.00%	4.31
	Min	2.25%	4.64%	15.00%	0.40%	13.00%	10.00%	1.99
Америкийн бүс нутаг, Австрали	Ave	4.21%	8.85%	38.75%	2.90%	35.85%	34.54%	4.75
	Max	5.00%	13.49%	48.00%	4.50%	45.60%	43.65%	6.73
	Min	3.25%	5.20%	35.00%	1.80%	31.50%	31.00%	3.56
Монгол Улстай эдийн засгийн чадамжаар ойролцоо улс орнууд	Ave	8.00%	15.71%	24.43%	3.27%	21.17%	16.43%	1.55
	Max	9.00%	18.30%	33.30%	6.30%	27.00%	24.30%	1.82
	Min	7.00%	13.17%	16.00%	1.50%	14.00%	8.00%	1.02



Азийн улс орнуудын хувьд инфляцын түвшинг хасаж тооцсон дундаж бодит хүү 15.86%, суурь хүү дээр нэмсэн дундаж эрсдэлийн шагнал 14.35%, банкны хүүг дундажар 3.10 дахин нэмэгдүүлэх замаар зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоосон байна.

ДУГНЭЛТ

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 18–ны өдрийн 01 тоот тогтоолоор баталсан мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчээс олгох зээлийн хүүгийн дээд хязгаарыг (жилийн 54%) дээрх аргачлалаар тооцож үзвэл инфляцын түвшинг хасаж тооцсон бодит хүү 46.10%, суурь хүү дээр нэмсэн эрсдэлийн шагнал 41.00%, арилжааны банкны зээлийн дундаж хүүг 3.18 дахин нэмэгдүүлсэн байна.

Улсын нэр	Суурь хүү	Банкны зээлийн хүү	Хүүний дээд хязгаар	Инфляц	Бодит хүү	Эрсдэлийн шагнал	Хүүгийн дээд хязгаар/Банкны хүү
A	B	C	D	E	D-E	D-B	D/C
Монгол Улс	13.00%	17.00%	54.00%	7.90%	46.10%	41.00%	3.18

Монгол улсад мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчээс олгох зээлийн хүүгийн дээд хязгаарыг жилийн 54%-иар тогтоосныг судалгаанд хамрагдсан улс орнуудтай харьцуулахад хүүгийн орлого олох бодит хүү болон суурь хүү дээр нэмэгдүүлсэн эрсдэлийн шагналын хэмжээгээр өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүрсэн байна. Харин арилжааны банкны зээлийн хүүг 3.1 дахин нэмэгдүүлсэн байгаа нь Азийн орнуудын дундаж жишигт байна.





ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХДАА ЮУ АНХААРАХ ВЭ?



Хэрэв та зуучлалын үйлчилгээ авахаар шийдсэн бол дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эсэхийг нягтлах; /www.frc.mn/
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын брокер, агент нь “Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын мэргэжилтний эрх олгох сургалт”-д хамрагдаж гэрчилгээ авсан эсэхийг тодруулах;
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагатай байгуулах гэрээний төрөл, зүйл заалтыг бүрэн уншиж, танилцах;



Гэрээнд дараах зүйлс тусгагдсан байх бөгөөд заавал бичгээр байгуулж, гарын үсгээр баталгаажуулах хэрэгтэй:

- Талуудын нэр, оршин суугаа хаяг/ оршин суугаа газар;
- Гэрээ байгуулсан он, сар, өдөр;
- Зуучлалын хөлс тодорхой тусгах. гм

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын гэрээний төрөл

Зуучлалын гэрээ

Зуучлах онцгой эрхийн гэрээ



ЗУУЧЛАЛЫН ГЭРЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?



Зуучлалын гэрээгээр зуучлагч нь зуучлуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх үүрэг хүлээнэ.

Иргэний хуулийн 410.1 зүйл

ЗУУЧЛАХ ОНЦГОЙ ЭРХИЙН ГЭРЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?



Зуучлах онцгой эрхийн гэрээгээр зуучлуулагч нь тодорхой хугацааны турш өөр зуучлагчийн үйлчилгээнээс татгалзах, зуучлагч энэ хугацаанд гэрээ байгуулахад туслалцаа үзүүлэх үүргийг хүлээнэ.

Өөрөөр хэлбэл энэ гэрээний дагуу зуучлуулагч тодорхой хугацаанд өөр зуучлагчтай хамтран ажиллахгүй.

Иргэний хуулийн 411.1 зүйл

Зуучлалын гэрээ болон зуучлах онцгой эрхийн гэрээний гол ялгаа юу вэ?



Зуучлалын гэрээ

- ❖ Хугацааг харилцан тохиролцоогүй бол хэдийд ч цуцалж болно.
- ❖ Хөлс, шагналын хэмжээг харилцан тохиролцоогүй бол тогтсон нийтлэг жишиг хэмжээгээр тохиролцсон гэж үзнэ.
- ❖ Зуучлуулагч нь өөр зуучлагчтай хамтран ажиллах эрхтэй.



Зуучлах онцгой эрхийн гэрээ

- ❖ Зөвхөн онцгой нөхцөл үүссэн үед цуцална. /Онцгой нөхцөл гэдэгт иргэний хуулийн 221 дүгээр зүйл/ зуучлах хугацаа зургаан сар өнгөрсөн бол хугацаа харгалзахгүйгээр цуцлах боломжтой.
- ❖ Худалдах-худалдан авах гэрээний зуучлалын хөлс 5%-аас хэтрэхгүй байх.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНК МАРОККОГИЙН ТӨМӨР ЗАМЫН САЛБАРЫГ ДЭМЖИХ НОГООН БОНДОД ХӨРӨНГӨ ОРУУЛНА.



Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) нь Марокко улсын үндэсний төмөр замын операторын (ONCF нь Мароккогийн төрийн өмчит компани бөгөөд үндэсний төмөр замын оператор юм) гаргасан 192 сая еврогийн ногоон бондоор дамжуулан төмөр замын салбарт 38.4 сая хүртэлх еврогийн хөрөнгө оруулалт хийлээ.

Энэхүү ногоон бонд нь Мароккогийн үндэсний төмөр замын операторын эрчим хүчний сүлжээг шинэчлэх, цахилгаан хөдлөх бүрэлдэхүүн авах, шинэчлэх, аюулгүй байдлын нэгж, тээврийн төлөвлөлтийн системийг боловсронгуй болгох зэрэг үйл ажиллагааг нь орчин үеийн болгоход зарцуулагдах зардлыг дахин санхүүжүүлэх юм.

ЕСБХБ нь энэхүү бондод хөрөнгө оруулсан цорын ганц гадаад хөрөнгө оруулагч болсон бөгөөд уг бондод Мароккогийн засгийн газрыг төлөөлөн "Tamwilcom" (Tamwilcom нь Мароккогийн Засгийн газрын эзэмшдэг төрийн өмчит санхүүгийн байгууллага) баталгаа гаргасан байна.

Энэхүү бондоор дахин санхүүжүүлж буй төслүүд нь ONCF-ийн үйл ажиллагааг илүү цахилгаан зарцуулалтад шилжүүлэх, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад дэмжлэг үзүүлэхээс гадна байгаль орчинд ээлтэй тээврийн хэлбэрт шилжихэд түлхэц үзүүлэх юм.

Эх сурвалж: www.ebrd.com

АВСТРАЛИЙН ЗГ-ААС ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ОРОН СУУЦ ХУДАЛДАЖ АВАХЫГ ХОРИГЛОЛОО.

Австралийн засгийн газар орон сууцны үнийн өсөлттэй тэмцэхийн тулд 2025 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн гадаадын хөрөнгө оруулагч, иргэдэд тогтсон үл хөдлөх хөрөнгө худалдаж авахыг 2 жилийн хугацаанд хориглох болсноо Орон сууцны асуудал эрхэлсэн сайд Клэр О'Нил 2 дугаар сарын 16-нд хийсэн мэдэгдэлдээ

дурдлаа. Энэхүү хязгаарлалт цаашид үргэлжлэх эсэхийг хязгаарлалтын үр дүнг хянан үзэж, сунгах эсэхийг шийднэ гэв.

Австралийн орон сууц нь дэлхийн хамгийн өртөг өндөртэй зах зээлийн нэг бөгөөд үл хөдлөх хөрөнгийн үнэ өсөх нь амьжиргааны өртгийг нэмэгдүүлэх, ялангуяа залуу гэр бүлд хэзээ ч байр худалдаж авах боломжгүй болох айдсыг төрүүлж буй нь сонгуулийн санал хураалтад нөлөөлнө гэж үзэж, засгийн газраас ийм шийдвэр гаргаж байгаа юм байна.



Сидней хотод дундаж орон сууцны үнэ сүүлийн 10 жилийн хугацаанд бараг 70 хувиар өсөж, орон сууцны дундаж үнэ одоо 1.2 сая австрали доллар (762 мянган ам.доллар) орчимд байна гэж үл хөдлөх хөрөнгийн зөвлөх CoreLogic Inc мэдээллээ. Үүнийг дагаад орон сууцны түрээсийн үнэ ч мөн өссөөр байна.


Энэ хориг арга хэмжээ нь орон сууцны үнэд бага зэрэг нөлөөлнө гэж үзэж байна. Австралийн Татварын албаны мэдээлснээр, гадаадад хөрөнгө оруулагчид 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар сүүлийн 12 сарын хугацаанд 4.9 тэрбум австрали долларын орон сууцны үл хөдлөх хөрөнгө, түүний дотор сул газар, шинээр баригдаж буй болон баригдсан орон сууц худалдан авсан байна.

Эх сурвалж: www.straitstimes.com

ДОНАЛЬД ТРАМП ХӨНГӨН ЦАГААН БОЛОН ГАНГЫН ИМПОРТЫН ТАТВАРЫГ НЭМЛЭЭ.

АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдөр АНУ-д импортоор орж ирж буй хөнгөн цагаан болон гангын бүх бүтээгдэхүүнд 25 хувийн татвар ноогдуулахаа мэдэгдэв.

Түүний хэлж байгаагаар АНУ нь дээрх түүхий эдийг өндөр чанартай эх орондоо үйлдвэрлэдэг байсан боловч сүүлийн жилүүдэд гаднаас хямд үнэтэй хэт их бүтээгдэхүүн импортлох болсноор АНУ-ын тус салбар уналтад ороод буй гэнэ.



АНУ-д нийлүүлдэг гангийн импортоор тэргүүлэгч улсууд нь Канад, Хятад, Мексик, Өмнөд Солонгос, Энэтхэг гэсэн улсууд аж. Үүнээс гадна энэ долоо хоногийн дундуур “Харилцан татвар”-ын бодлого зарлаж аль нэг улс орон АНУ-ын бараанд хэр хэмжээний татвар ногдуулна, түүнтэй адил хэмжээний татварыг тухайн улсад ногдуулж эхлэх юм байна.

Эх сурвалж: www.reuters.com

ТРАМПЫН ТАРИФЫН БОДЛОГЫН ЭСРЭГ БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВЧ КОКСЖИХ НҮҮРСНИЙ УРСГАЛ БОЛОН ҮНИЙГ ӨӨРЧИЛЖЭЭ.



АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп БНХАУ-аас импортолж буй бүх бүтээгдэхүүнд 10 хувийн татвар ногдуулсны хариуд БНХАУ 2 дугаар сарын 4-нд АНУ-ын нүүрс болон шингэрүүлсэн хий (LNG)-д 15 хувийн импортын татвар, түүхий газрын тосонд 10 хувийн татвар ногдууллаа.

Энэхүү тариф нь дэлхийн нүүрс, LNG, түүхий нефтийн хамгийн том импортлогч Хятад болон LNG-ийн хамгийн том экспортлогч, нүүрс, түүхий нефтийн хэмжээгээр дөрөвдүгээрт ордог АНУ хоорондын эрчим хүчний худалдааг устгахад хангалттай өндөр тариф юм.

Гэсэн хэдий ч Хятадын түүхий нефтийн болон LNG-ийн импортод АНУ-ын эзлэх хувь бага буюу ойролцоогоор 2 хувь ба 5 хувь байгаа нь дэлхийн зах зээлд ямар нэгэн хүндрэлгүйгээр дасан зохицож чадна гэсэн үг юм.

Харин коксжих нүүрс буюу голчлон ган үйлдвэрлэхэд ашигладаг түлш болох металлургийн нүүрсний хувьд бол энэ өөр түүх юм.

2024 онд Хятадын далайгаар авсан коксжих нүүрсний нийт импортын хэмжээ 43.02 сая тонн байсан бөгөөд үүний 5.02 сая тонн буюу 11.7 хувийг АНУ нийлүүлсэн гэж түүхий эдийн шинжээч Kpler мэдээлэв.

АНУ нь БНХАУ-д далайгаар коксжих нүүрс нийлүүлсэн хэмжээгээрээ 4-т ордог ба 15.91 сая тонноор Австрали, 11.68 сая тонноор Орос, 7.79 сая тонноор Канадын дараа орж байна.

Хэрэв шинэ тариф нь АНУ-ын коксжих нүүрсийг өрсөлдөх чадваргүй болговол БНХАУ-ын гангийн үйлдвэрлэгчид өөр хувилбар хайж хэрэгтэй болно.

Мэдээжийн хэрэг АНУ-ын коксжих нүүрс экспортлогчид БНХАУ-ын зах зээлд үлдэхийн тулд тээврийн өртгийг хөнгөлөх сонголт хийх боломжтой ч гол худалдан авагч болох Энэтхэг, Япон, Өмнөд Солонгос зэрэг бусад импортлогчдод зарах магадлал өндөр байна.

2025 онд БНХАУ-ын коксжих нүүрсний эрэлт 2024 оноос буурахгүй тогтмол хэвээр байх таамаглал байгаа тул БНХАУ нь АНУ-ын нийлүүлэлтийг орлох коксжих нүүрсний эх үүсвэрийг хаанаас авах боломжтой вэ гэдэг асуулт гарна.

БНХАУ руу газраар галт тэрэг болон ачааны автомашинаар нийлүүлэлт хийдэг гол нийлүүлэгч болох Монголоос илүү их коксжих нүүрс гаргахыг хичээх боловч далайгаар дамжуулан нийлүүлэлт хийгддэг коксжих нүүрс нь голдуу далайн эргийн дагуух гангийн үйлдвэрүүдэд нийлүүлэгддэг тул энэ нийлүүлэгчийг сонгох магадлал бага гэж үзэж байна.

БНХАУ нь АНУ-ын коксжих нүүрснээс татгалзан Австралиас илүү ихийг импортолж, харин Энэтхэгийн гангийн үйлдвэрүүд Австралиас бага, АНУ-аас их хэмжээгээр авах явдал юм. Энэ бол хамгийн боломжит хувилбар бөгөөд эцсийн дүндээ үнэ ямар нэгэн хэмжээгээр нэмэгдэх магадлалтай юм.

Хэрэв БНХАУ-ын худалдан авагчид Австралийн, магадгүй Канадын коксжих нүүрсийг илүү их худалдан авахаар болбол Австралийн нүүрсний үнэ АНУ-ынхаас давж гарах магадлалтай ба харин АНУ-ын нүүрсний экспортлогчид БНХАУ руу ачигдсан нүүрсээ зарах өөр худалдан авагч хайж олох шаардлагатай болох юм.

Эх сурвалж: www.reuters.com

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

S&P 500 /[^]GSPC/

5,955.25 -28.00 (-0.47%)



Nikkei 225 /[^]N225/

37,814.04 -423.75 (-1.11%)



FTSE 100 /[^]FTSE/

8,668.67 +9.69 (+0.11%)



NASDAQ Composite ([^]IXIC)

19,026.39 -260.54 (-1.35%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

ШУДАРГА ЕС-ХӨГЖИЛ ДЭВШИЛД

110

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС
/үнэ төлбөргүй/

АВАГИА
110

ХИНА СУТГА
110

АНИТ СОМРЛААН
30944
110

АВИАГАТЫН
ТӨМӨРХ ГАЗАР